



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндун сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/79/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Г.Ганцэцэг

Утас: 70003775,

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.6.1 Төсвийн төлөвлөлт	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ЗГ Засгийн газар

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.2.25 № 265
танай -ны № -Т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Б.ХҮРЭЛБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020971

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,471,782.90</u>	<u>23,471,782.90</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	23,471,782.90	23,471,782.90
354	Хангамжийн материал	23,471,782.90	23,471,782.90
35410	Бичиг хэргийн материал	9,425,651.00	9,425,651.00
35420	Аж ахуйн материал	14,046,131.90	14,046,131.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>278,677,355.62</u>	<u>281,469,507.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	278,677,355.62	281,469,507.78
392	Биет хөрөнгө	274,919,355.62	277,711,507.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	238,095,849.12	238,095,849.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,693,714.72)	(28,040,572.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,858,142.62	82,089,465.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,649,775.15)	(34,677,468.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,880,128.11	16,880,128.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,071,374.78)	(10,999,747.78)
39209	Зам, гүүрийн байгууламж	10,341,692.02	10,341,692.02
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,262,542.56)	(2,758,813.72)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,373,610.00	1,373,610.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,375,811.00	9,375,811.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,671,940.04)	(5,311,915.88)
39217	Ном	1,343,470.00	1,343,470.00
393	Биет бус хөрөнгө	3,758,000.00	3,758,000.00
39301	Програм хангамж	130,000.00	130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(130,000.00)	(130,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,758,000.00	3,758,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>302,149,138.52</u>	<u>304,941,290.68</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>302,149,138.52</u>	<u>304,941,290.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	302,149,138.52	304,941,290.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,800,603.51	224,800,603.51
51101	Өмч: - төрийн	224,800,603.51	224,800,603.51
512	Хуримтлагдсан үр дүн	(9,491,095.67)	(6,698,943.51)
51210	Өмнөх үеийн үр дүн	(4,198,770.05)	(9,491,095.67)
51220	Тайлант үеийн үр дүн	(5,292,325.62)	2,792,152.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	86,839,630.68	86,839,630.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>302,149,138.52</u>	<u>304,941,290.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	81,093,200.00	83,347,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	81,093,200.00	83,347,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	80,283,200.00	83,347,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	80,283,200.00	83,347,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	810,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	810,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	101,628,851.24	101,786,170.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,628,851.24	101,786,170.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,087,672.58	93,648,151.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,992,999.61	52,518,575.88
210101	Үндсэн цалин	47,083,608.61	43,684,140.92
210105	Гэрээт ажлын хөлс	8,909,391.00	8,834,434.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,243,111.04	7,830,100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,788,108.26	5,511,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	462,000.00	580,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	260,402.78	464,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	577,900.00	115,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,154,700.00	1,158,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,694,860.69	9,322,804.65
210301	Гэрэл, цахилгаан	1,595,477.69	1,711,014.65
210302	Түлш, халаалт	9,099,383.00	7,611,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,013,503.00	2,220,500.00
210401	Бичиг хэрэг	838,750.00	483,600.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	199,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	860,000.00	782,100.00
210404	Ном, хэвлэл	160,600.00	487,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,954,153.00	268,300.00
2105	Нормативт зардал	200,000.00	230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,657,000.00
210604	Урсгал засвар	-	2,657,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	280,000.00
210702	Дотоод албан томилолт	-	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,313,198.24	18,439,170.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,313,198.24	18,439,170.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,541,178.66	8,138,019.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	340,000.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,201,178.66	8,138,019.47
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,201,178.66	8,138,019.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,535,651.24)	(18,439,170.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(20,535,651.24)	(18,439,170.84)
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	81,093,200.00	83,347,000.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	224,800,603.51	86,839,630.68	(9,491,095.67)	302,149,138.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,800,603.51	86,839,630.68	(9,491,095.67)	302,149,138.52
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,800,603.51	86,839,630.68	(9,491,095.67)	302,149,138.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,800,603.51	86,839,630.68	(9,491,095.67)	302,149,138.52
Тайлант үеийн үр дүн	-	-	2,792,152.16	2,792,152.16
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,800,603.51	86,839,630.68	(6,698,943.51)	304,941,290.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	81,093,200.00	83,347,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	81,093,200.00	83,347,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	80,283,200.00	83,347,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	80,283,200.00	83,347,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	810,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	810,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	81,093,200.00	83,347,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,093,200.00	83,347,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,552,021.34	75,208,980.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,992,999.61	52,518,575.88
210101	Үндсэн цалин	47,083,608.61	43,684,140.92
210105	Гэрээт ажлын хөлс	8,909,391.00	8,834,434.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,243,111.04	7,830,100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,788,108.26	5,511,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	462,000.00	580,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	260,402.78	464,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	577,900.00	115,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,154,700.00	1,158,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,694,860.69	9,322,804.65
210301	Гэрэл, цахилгаан	1,595,477.69	1,711,014.65
210302	Түлш, халаалт	9,099,383.00	7,611,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,091,050.00	2,220,500.00
210401	Бичиг хэрэг	803,150.00	483,600.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	199,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	860,000.00	782,100.00
210404	Ном, хэвлэл	497,900.00	487,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	730,000.00	268,300.00
2105	Нормативт зардал	200,000.00	230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2657000.00
210604	Урсгал засвар	0.00	2657000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	280000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	280000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,330,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,541,178.66	8,138,019.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	340,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,201,178.66	8,138,019.47
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,201,178.66	8,138,019.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,347,000.00	75,208,980.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,347,000.00	75,208,980.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,347,000.00	75,208,980.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,024,100.00	52,518,575.88
210101	Үндсэн цалин	48,980,600.00	43,684,140.92
210105	Гэрээт ажлын хөлс	9,043,500.00	8,834,434.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,830,100.00	7,830,100.00
210201	Тэтгэврийн даатгал	5,511,700.00	5,511,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	580,000.00	580,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	368,900.00	464,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	211,000.00	115,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,158,500.00	1,158,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,421,000.00	9,322,804.65
210301	Гэрэл, цахилгаан	1,720,000.00	1,711,014.65
210302	Түлш, халаалт	7,701,000.00	7,611,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,334,000.00	2,220,500.00
210401	Бичиг хэрэг	483,800.00	483,600.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	199,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	869,100.00	782,100.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	487,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	281,100.00	268,300.00
2105	Нормативт зардал	230,000.00	230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	230,000.00	230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,657,800.00	2,657,000.00
210604	Урсгал засвар	2,657,800.00	2,657,000.00
2107	Томилолт, зочны зардал	520,000.00	280,000.00
210702	Дотоод албан томилолт	520,000.00	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,330,000.00	150,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	83,347,000.00	75,208,980.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,347,000.00	75,208,980.53
131001	Улсын төсвөөс санхүүжих	83,347,000.00	75,208,980.53
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Г.Ганцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Баяндун сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Соёлын төвийн нийтлэг чиг үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалт, байгууллага иргэдтэй харилцах хэм хэмжээг тодорхойлох, үйл ажиллагааг зохицуулахад оршино. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяндун сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 80,283.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,605.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,204.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 23,741.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 281,469.5 мянган төгрөг болж 21,231.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 16,031.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Соёлын яамнаас үнэ төлбөргүй авсан 5,200.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,241.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого болон улсын төсвөөс санхүүжих орлого өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 157.3 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал болон урсгал засварын зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 83,347.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 83,347.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 83,347.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 83,347.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 83,347.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 83,347.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 75,209.0 мянган төгрөг буюу 90.2 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 8,138.0 мянган төгрөг буюу 9.8 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлого зарлага байхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баяндун сумын Соёлын төв нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 орлогын 65,890.1 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна. Бусад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажилласан байна. Шилэн дансны мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад

төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитад түүврээр шалгагдсан бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах
- Мэргэжлийн бус нягтлан бодогчдод зориулж нягтлан бодох бүртгэлийн арга аргачлал, төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг таниулсан сургалт зохион байгуулах
- НӨАТ-ын цахим төлбөрийн баримтын бараа, ажил үйлчилгээний нэр төрлийг дэлгэрэнгүй жагсаалтаар хүлээн авч төсвийн гүйлгээг хийж байх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 66,395.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 60,945.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 5,449.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 59,752.1 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 -т хамаарах “Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6.1 -д Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.2.6 –д “Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/ -ын мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх үүрэгтэй” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, Албан шаардлага өгөх

2. Тайлант онд 2 ААН-ээс 1,193.8 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын” 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах, Албан шаардлага өгөх.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллар эрэмбэлэн харуулав. Үүнд :

1. Зардлын хэмнэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт : МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17 ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1 " үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах " зүйл заалтын хэрэгжилтийг хангаагүй, 5,449.5 мянган төгрөгийн хэмнэлт гаргах тухай удирдлагаас тушаал шийдвэр гаргаж ажиллаагүй.

1.2 Өгсөн зөвлөмж : Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д " төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана " гэж заасны дагуу төсвийн хэмнэлтийг гаргах тушаал гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяндун сумын Соёлын төв	3	66,395.4	-	-	-	-	2	60,945.9	1	5,449.5